



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот


Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6 дахь заалт, АНУ-ын Индианагийн их сургуулийн урилга болон нэхэмжлэхийг үндэслэн ТУШААХ нь:

1.Л.Эрдэнэчимэгийг АНУ-ын Индианагийн их сургуульд 1 жилийн хугацаатайгаар соёл, урлагийн чиглэлээр суралцуулсугай.

2.Л.Эрдэнэчимэгийн нэг жилийн сургалтын зардлыг Сургалтын төрийн сангаас олгосугай.

3.Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН